



МОНГОЛБАНК

МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

(Монгол Улсын төлбөрийн тэнцлийн талаарх ойлголт, уг нэгтгэлийг боловсруулах, тайлагнахтай холбоотой үйл ажиллагааг олон нийтэд хүргэх, ил тод нээлттэй байдлыг хангах зорилгоор энэхүү танилцуулгыг боловсруулав¹)

Улаанбаатар
2011 оны 12 дугаар сар

¹ Монголбанкны цахим хуудсанд нийтлэгдэнэ.

Агуулга

I. Ерөнхий мэдээлэл	3
1.1 Эрх зүйн орчин	3
1.2 Институциональ зохион байгуулалт.....	4
1.3 Бусад байгууллагатай хамтын ажиллагаа	4
1.4 Сургалт, зөвлөгөөн.....	4
II. Аргачлал	4
2.1 Үндсэн ойлголт, тодорхойлолт	5
2.2 Хамрах хүрээ.....	5
2.3 Ангилал	5
2.4 Бүртгэлийн суурь.....	5
2.5 Төлбөр тэнцэлтэй холбоотой заавар, журам.....	5
2.5.1 Гадаад гүйлгээний тайлан гаргах заавар	6
2.5.2 Гадаад худалдааны барааны статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал.....	6
2.5.3 Гадаад зээлийн бүртгэлийн журам.....	6
III. Чанар, хамрах хүрээ	7
3.1 Мэдээллийн эх сурвалж	7
3.1.1 Банкуудын гадаад гүйлгээний тайлан	7
3.1.2 Байгууллага, аж ахуйн нэгжийн шууд мэдээ	7
3.1.3 Түүвэр судалгаа	7
3.2 Мэдээллийн эх сурвалжийн чанарын шалгалт	8
IV. Боловсруулалт.....	8
4.1 Мэдээлэл цуглуулах	8
4.2 Боловсруулалт, нэгтгэл	8
4.3 Гүйцэтгэлийн хяналт.....	8
4.4 Гүйцэтгэлд тохируулга хийх бодлого	8
V. Нээлттэй байдал.....	9
5.1 Мэдээллийг тархаах	9
5.2 Аргачлалтай танилцах боломж	9
5.3 Хэрэглэгчдэд үзүүлэх туслалцаа.....	9
VI. Хэрэглээ	10

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төлбөрийн тэнцэл, гадаад хөрөнгө оруулалтын позицийн статистикийн асуудал нь өнгөц харахад “статистик” гэсэн утгаар техникийн шинжтэй асуудал гэж ойлгогдож магадгүй ч, энэ нь аливаа эдийн засгийн гадаад тэнцлийг илэрхийлэгч, макро эдийн засгийн хамгийн чухал үндсэн үзүүлэлтийн нэг юм.

Олон улсын нийтлэг аргачлалын дагуу “төлбөрийн тэнцэл” гэж аливаа улсын эдийн засгийн харьяатын гадаад эдийн засагтай буюу эдийн засгийн харьяат бустай тодорхой хугацаанд хийсэн худалдаа, үйлчилгээ, хөрөнгө, санхүүгийн болон бусад урсгалын орлого, зарлагын гүйлгээг системчлэн нэгтгэсэн статистикийн тайланг хэлдэг. Энэхүү статистик нэгтгэл нь аливаа улсын гадаад ертөнцтэй харилцах эдийн засгийн харилцааг харуулахаас гадна, тус улсын эдийн засгийн ерөнхий төлөв байдал, хандлагын талаарх мэдээллийг харуулж байдаг.

Төлбөрийн тэнцлийн статистик нь анх 14 дүгээр зуунд Англи улсад хэрэглэгдсэн бол статистик нэгтгэлийг Дэлхийн 1 дүгээр дайны дараагаас эхлэн орчин үеийн хэлбэрээр боловсруулж эхэлжээ. Засгийн газрын эдийн засаг дахь оролцоо нэмэгдэхийн хэрээр эдийн засгийн бодлогыг зөвхөн онол-чанарын шинжилгээний хувьд бус тоон шинжилгээний үр дүнг ашиглан боловсруулах шаардлага тавигдаж байлаа. Үүнтэй холбоотойгоор улс орнуудын бусад улс орнуудтай хийж буй эдийн засгийн гүйлгээг тодорхойлох, ангилах, тооцох стандарт аргачлалуудыг боловсруулахад улс орнууд анхаарч эхэлсэн байна. Энэхүү шаардлагад үндэслэн ОУВС-гаас “Төлбөрийн тэнцлийн гарын авлага²”-ыг 1948 онд, НҮБ-гаас “Үндэсний тооцооны систем”-ийн гарын авлагыг 1953 онд тус тус боловсруулжээ.

Монгол Улс төлбөрийн тэнцлийн жилийн гүйцэтгэлийг 1989 оноос, улирлын гүйцэтгэлийг 1996 оноос эхлэн боловсруулж, макро эдийн засгийн судалгаа, шинжилгээ, бодлогын шийдвэрт ашиглаж ирсэн.

1.1 Эрх зүйн орчин

“Валютын зохицуулалтын тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 2-т “Монгол Улсын гадаад төлбөрийн тэнцэл зохиож, биелэлтэд нь хяналт тавих” эрхийг Засгийн газрын бүрэн эрхэд хамааруулсан байдаг билээ.

Гэтэл төлбөрийн тэнцлийг боловсруулах мэдээллийн гол эх сурвалж нь төв банкинд мэдээлдэг “Банкны гадаад гүйлгээний тайлан (ITRS)” тул Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны дарга, Монголбанкны Ерөнхийлөгч нарын 1996 оны 86/35/60 дугаар хамтарсан тушаалаар Монголбанк нь төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлийг, Засгийн газар нь төлбөрийн тэнцлийн төсөөллийг боловсруулахаар тогтсон байдаг.

Монголбанк нь төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлийг боловсруулахдаа “Валютын зохицуулалтын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 7 дахь заалт³, “Статистикийн тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 4 дэх заалт⁴-ын дагуу иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллагаас мэдээлэл авч, “Төв банкны тухай” хуулийн 29 дүгээр зүйлийн 2⁵-т зааснаар энэхүү мэдээллийн эх сурвалжийн нууцлалыг ханган ажиллаж байна.

²ОУВС-гийн Статистикийн газраас энэхүү гарын авлагын сүүлийн буюу 6 дахь хувилбарын “хэвлэлийн өмнөх хэвлэлт”-ийг 2008 оны 12 дугаар сард хэвлүүлсэн.

³ валютын гүйлгээний тайлан, мэдээ гаргах журмыг тогтоох

⁴ Статистикийн мэдээллийг Үндэсний статистикийн хорооноос баталж, зөвшөөрсөн маягтаар мэдээлэгчээс гаргуулан авах

⁵ Монголбанкны албан тушаалтан, Хяналтын зөвлөлийн дарга, гишүүн нь албан үүргийнхээ дагуу олж авсан мэдээллийн нууцлалыг хуульд зааснаас бусад тохиолдолд үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөнөөс хойш ч задруулж үл болно.

1.2 Институциональ зохион байгуулалт

Монголбанкны Валют, эдийн засгийн газрын Төлбөрийн тэнцлийн статистик, судалгааны хэлтэс нь Монгол Улсын төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлийг боловсруулан гаргаж байна. Энэхүү хэлтэс нь нийт 13 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд үүний 7 ажилтан нь⁶ төлбөрийн тэнцлийг дансд тус бүрээр хуваан авч хариуцан ажилладаг.

Төлбөрийн тэнцлийг боловсруулахдаа “Удирдлагын мэдээллийн систем (Report Management System)-ийг ашигладаг бөгөөд энэхүү систем нь банк, аж ахуйн нэгж, төрийн байгууллагаас авч буй мэдээллийн нууцлалыг хадгалах, аюулгүй ажиллагааг хангах, төлбөрийн тэнцлийн тооцооллыг автоматжуулдаг систем юм.

1.3 Бусад байгууллагатай хамтын ажиллагаа

Монголбанк нь төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл, төсөөллийг боловсруулах ажлын хүрээнд дараах байгууллагуудтай тусгайлсан гэрээгээр хамтран ажилладаг:

Хүснэгт 1. Хамтран ажиллах гэрээтэй байгууллагууд

№	Байгууллагын нэр	Гэрээний нэр	Байгуулсан огноо
1	Гаалийн ерөнхий газар	Монголбанк, Гаалийн ерөнхий газрын хамтран ажиллах журам	2008.10.03
2	Гадаадын шууд хөрөнгө оруулалтын газар	Монголбанк, Гадаадын хөрөнгө оруулалтын газрын хамтран ажиллах журам	2011.04.13
3	Гадаад хэргийн яам, Сангийн яам, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо	Гадаад секторын бодлогын асуудлаар хамтран ажиллах санамж бичиг	2011.01.17

Түүнчлэн төлбөрийн тэнцлийн төсөөллийг гаргах ажлын хүрээнд экспорт, импорт болон хөрөнгө оруулалтын чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг томоохон аж ахуйн нэгжүүдтэй “Мэдээлэл солилцох гэрээ” байгуулан ажиллаж байна.

1.4 Сургалт, зөвлөгөөн

Монголбанкнаас төлбөрийн тэнцлийн статистикийн чанарыг сайжруулах, хамрах хүрээг нэмэгдүүлэх чиглэлээр (i) банкуудын гадаад гүйлгээний тайлан хариуцсан ажилтнуудад зориулан “Гадаад гүйлгээний тайлан” сэдэвт сургалтыг улирал тутам, (ii) аж ахуйн нэгж, байгууллагын мэдээг боловсруулдаг нягтлан бодогч, эдийн засагч нарт зориулан “төлбөрийн тэнцлийн шууд мэдээ” сэдэвт сургалтыг тухай бүр, (iii) Монгол Улсын гадаад секторын талаарх бодлого, судалгаа, статистик үзүүлэлтийн талаарх “Гадаад секторын зөвлөгөөн”-ийг хагас жил буюу жил тутам төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудад зориулан тус тус зохион байгуулж байна. Өмнөх зөвлөгөөний талаарх мэдээллийг Монголбанкны цахим хуудаснаас авна уу.

II. АРГАЧЛАЛ

Монголбанк нь төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлийг ОУВС-гийн төлбөрийн тэнцлийн 5-р гарын авлагад үндэслэн боловсруулж, Монголбанкны Ерөнхийлөгч, Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 439/0186 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Монгол Улсын төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлийг зохиох аргачлал”-ын дагуу боловсруулж, нийтэд мэдээлж байна.

⁶Холбоо барих хаягийг хавсралтаас үзнэ үү

2.1 Үндсэн ойлголт, тодорхойлолт

Монгол Улсын төлбөрийн тэнцэл нь Монгол Улсаас гадаад орнуудтай тайлант хугацаанд гадаад худалдаа, эдийн засгийн бусад харилцааны хүрээнд хийсэн төлбөр тооцооны гүйлгээг нэгтгэн харуулдаг статистикийн хүснэгт юм.

"Төлбөрийн тэнцэл" гэж тодорхой хугацаанд эдийн засгийн харьяат болон эдийн засгийн харьяат бусын хооронд хийсэн худалдаа, үйлчилгээ, орлого, урсгал шилжүүлэг, санхүүгийн болон хөрөнгийн урсгалын орлого, зарлагын гүйлгээг системчлэн нэгтгэсэн статистикийн тайланг хэлнэ.

Төлбөрийн тэнцэлд эдийн засгийн харьяат ба эдийн засгийн харьяат бусын хооронд хийгдсэн ажил гүйлгээг бүртгэхдээ орлого ба зарлагын давхар бичилтийн зарчмыг мөрдөнө. Аливаа гүйлгээ нь кредит бичилтээр орлогын талд эх үүсвэр нэмэгдүүлэхийн зэрэгцээ дебет бичилтээр зарлагын талд эх үүсвэрийг хорогдуулах бичилт хийгдэнэ.

Монгол Улсын төлбөрийн тэнцэлд аливаа гүйлгээг америк доллараар бүртгэж, төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлийг сая америк доллараар тайлагнадаг бөгөөд төгрөгийн гүйлгээг америк долларт хөрвүүлэхдээ Монголбанкнаас зарласан тухайн жил, улирлын дундаж ханшийг хэрэглэнэ.

Төлбөрийн тэнцэлд гүйлгээг бүртгэлийн аккруэл суурьт тулгуурлан эдийн засгийн өртөг бий болсон, хөрвүүлсэн, солилцсон, шилжүүлсэн цаг хугацаанд тооцон бүртгэнэ.

2.2 Хамрах хүрээ

Төлбөрийн тэнцэл нь эдийн засгийн харьяат ба эдийн засгийн харьяат бусын хооронд хийгдсэн бүх гүйлгээг хамарна. Тодруулбал, банк, банк бус санхүүгийн байгууллагаар бэлэн болон бэлэн бусаар хийгдсэн, үүргийн худалдаагаар хийгдсэн бэлэн төлбөр тооцоо, гадаадын банкууд дахь дансаар төлбөр нь хийгдсэн хэдий ч Монгол улсын хилээр оруулж ирсэн бараа, түүнчлэн интернетээр авч буй үйлчилгээ, санхүүгийн гүйлгээ бүгд хамрагдана.

2.3 Ангилал

Төлбөрийн тэнцлийг боловсруулахад “Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэгдсэн ангилал” (БҮНА) (ҮСГ-ын даргын 2007 оны 01/46 тоот тушаалаар батлагдсан), “Эдийн засгийн секторын ангилал” (ҮСХ-ны 2008 оны 01/57 тоот тушаалаар батлагдсан)-ыг мөрддөг.

Түүнчлэн санхүүгийн дансыг эдийн засгийн сектороор буюу Засгийн газар, Монголбанк, Банк, Бусад сектор гэж 4 ангилдаг. Энэ нь макро эдийн засгийн бусад үзүүлэлтийн тооцоолол, эдийн засгийн салбараар дүн шинжилгээ хийх зэрэгт голлон ашиглагдана.

2.4 Бүртгэлийн суурь

Төлбөрийн тэнцлийн гүйлгээг зах зээлийн үнээр бүртгэнэ. Өөрөөр хэлбэл, тухайн гүйлгээ гарах үеийн зах зээлийн үнэ, валютын ханшаар бүртгэж тэнцэлд тусгана.

2.5 Төлбөр тэнцэлтэй холбоотой заавар, журам

Монгол Улсын төлбөрийн тэнцэл, гадаад хөрөнгө оруулалтын позицгийн нэгтгэлийг сайжруулах зорилгоор дараах 4 заавар, журам, аргачлалыг холбогдох байгууллагуудтай хамтран баталж, мөрдөн ажиллаж байна. Үүнд:

- Гадаад гүйлгээний тайлан гаргах заавар;
- Монгол Улсын гадаад худалдааны барааны статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал;
- Төлбөрийн тэнцлийг зохиох аргачлал;

- Гадаад зээлийн бүртгэлийн журам.

2.5.1 Гадаад гүйлгээний тайлан гаргах заавар

Банкны гадаад гүйлгээний тайлан нь арилжааны банкуудаар дамжин хийгдэж байгаа манай улсын “эдийн засгийн харъяат” болон “эдийн засгийн харъяат бус” хоорондын гадаад төлбөр тооцооны дүн нэгтгэл юм.

Банкны гадаад гүйлгээний тайлан гаргах зааврыг хамгийн сүүлд 2000 онд шинэчилснээс хойш эдийн засгийн гадаад харилцаа тэлж, гадаад төлбөр тооцооны урсгал нэмэгдсэний зэрэгцээ Монголбанкны хувьд i) Банк бус санхүүгийн байгууллагын гадаад мөнгөн гуйвуулгын мэдээг авах, ii) гадаад гүйлгээний эдийн засгийн ангиллыг нэмэгдүүлж, шинээр гарч буй гүйлгээнүүдийг хамруулах, iii) гадаад гүйлгээний мэдээг валютын нэгж тус бүрээр авч ханшийн тооцоо, судалгаанд ашиглах зэрэг шаардлага гарч ирсэн.

Иймд Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 270/89 дугаар хамтарсан тушаалаар “Гадаад гүйлгээний тайлан гаргах заавар”-ыг шинэчлэн баталж, банкууд болон гадаад мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхэлдэг банк бус санхүүгийн байгууллагуудаас холбогдох мэдээллийг авч, сар бүр нэгтгэн гаргаж байна. Гадаад валютын мэдээг үндсэн валют тус бүрээр авч эхэлсэн нь төгрөгийн бодит ханшийн тооцоолол, суурь хүчин зүйлсийн судалгааны үндсэн өгөгдлийн нэг болж байна.

2.5.2 Гадаад худалдааны барааны статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал

НҮБ-ын олон улсын худалдааны статистикийн зааврын дагуу гадаадын болон үндэсний валютын экспорт, импортын дүнг гадаад худалдааны дүнгээс хасч тооцдог. Гэтэл Монгол Улсын хилээр оруулж, гаргаж байгаа гадаад валютын зузаатгал, үндэсний мөнгөн тэмдэгт нь “Гадаад худалдааны гаалийн статистик мэдээлэл”-д өөрийн нэрлэсэн дүнгээр тооцогдож байсан нь гадаад худалдааны алдагдлыг 2008 оны 8 дугаар сарын эцсийн байдлаар 300.0 орчим сая ам.доллараар нэмэгдүүлсэн байна.

Иймд холбогдох байгууллагууд хамтран Ажлын хэсгийг байгуулж, дээрх үзүүлэлтийг залруулах, бусад үзүүлэлтийг сайжруулах зорилгоор “Монгол Улсын гадаад худалдааны барааны статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлал”-ыг шинэчлэн боловсруулж, Үндэсний статистикийн хорооны дарга, Сангийн сайд, Гаалийн ерөнхий газрын даргын 2009 оны 0117/42/069 дугаар хамтарсан тушаалаар батлуулсан.

Энэхүү аргачлалыг батлуулан барааны гадаад худалдааны статистикт шаардлагатай залруулгыг хийснээр гадаад худалдааны 2007 оны алдагдал 106.6 сая ам.доллараар, 2008 оны алдагдал 360.9 сая ам.доллараар тус тус буурч бодит гүйцэтгэл нь хангагдсан.

2.5.3 Гадаад зээлийн бүртгэлийн журам

“Валютын зохицуулалтын тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 6-д “Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь өөрсдийн гадаадаас авсан валютын зээлийг Монголбанкинд бүртгүүлнэ” гэж заасныг хэрэгжүүлэх зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгчийн 1998 оны 45 дугаар тушаалаар “Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотойгоос бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн гадаадаас авсан валютын зээлийн бүртгэлийн маягт”-ыг баталсан.

Гэтэл сүүлийн хэдэн жилд хувийн хэвшлийн салбар дахь гадаад өр, зээлийн хэмжээ эрчимтэй нэмэгдсэн нь дээрх маягтаар авч байсан мэдээллийн хүрээнд энэ салбарын гадаад өрийн тайлан гаргах, төлбөрийн тэнцлийг сайжруулах, гадаад хөрөнгө оруулалтын позицгийн нэгтгэлийг гаргах болон холбогдох судалгааны ажлуудыг гүйцэтгэхэд мэдээллийн эх сурвалж болж чадахгүй байв.

Иймд бүртгэлийн маягтыг шинэчлэн, улмаар бүртгэлийн үйл ажиллагааг хэвшүүлэн ажиллахтай уялдан Монголбанкны Ерөнхийлөгчийн 2009 оны 723 дугаар тушаалаар “Банк, аж ахуйн нэгж, байгууллагын гадаад зээлийг бүртгэх” журмыг баталж, мөрдөн ажиллаж байна.

Ш. ЧАНАР, ХАМРАХ ХҮРЭЭ

3.1 Мэдээллийн эх сурвалж

Монгол Улсын төлбөрийн тэнцлийн мэдээллийг ерөнхийд нь (i) банкуудын гадаад гүйлгээний тайлан, (ii) байгууллага, аж ахуйн нэгжийн шууд мэдээ, (iii) түүвэр судалгаа, (iv) бусад эх сурвалж гэж ангилдаг.

Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлийг боловсруулахдаа эдгээр мэдээллийг бусад эх сурвалжтай тулгаж, нягтлан шалгасны дараа тоог ашиглах, зарим үзүүлэлтийг тооцооллын өгөгдөл байдлаар авах зэрэг олон хэлбэрээр ашигладаг.

3.1.1 Банкуудын гадаад гүйлгээний тайлан

Өмнөх хэсэгт дурдсанчлан төлбөрийн тэнцлийн мэдээллийн гол эх сурвалж нь банкуудын гадаад гүйлгээний тайлан байдаг. Тэгвэл энэхүү мэдээний анхдагч эх сурвалж болох банкуудын гадаад гуйвуулгын маягтыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд үнэн зөв, оновчтой бөглөх нь тайлан мэдээллийн чанарт шууд нөлөөлдөг.

3.1.2 Байгууллага, аж ахуйн нэгжийн шууд мэдээ

Энэ ангиллын эх сурвалжид Гаалийн ерөнхий газар, Сангийн яам, Гадаад харилцааны яам, Гадаадын хөрөнгө оруулалтын газар, Хил хамгаалах газар, Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв зэрэг байгууллагуудын мэдээнээс гадна төлбөрийн тэнцлийн мэдээлэл авах шалгуур үзүүлэлтийг хангасан аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлдэг шууд мэдээ багтдаг.

Аж ахуйн нэгж, байгууллагын шалгуур үзүүлэлтийг төлбөрийн тэнцлийн дансд тус бүрт тооцдог бөгөөд шалгуур үзүүлэлтэд багтсан байгууллага нь тухайн дансны хандлагыг тодорхойлогч аж ахуйн нэгж байгууллага байдаг. Энэ оны 10 дугаар сарын байдлаар нийт 45 аж ахуйн нэгжээс шууд мэдээ авч байна.

3.1.3 Түүвэр судалгаа

Монголбанк нь бусад улс орнуудын нэгэн адил зарим үзүүлэлтийг түүвэр судалгааны үр дүнг ашиглан тооцож, гүйцэтгэлд тусгадаг. Энэ зорилгоор дараах түүвэр судалгааг хийж байна:

1. Хувийн гуйвуулгын түүвэр судалгаа,
2. Гадаадын хөрөнгө оруулалтын судалгаа,
3. Монгол Улсад томилолтоор ажилласан олон улсын болон гадаадын байгууллагуудын ажиллагсдын томилолтын зардлын судалгаа,
4. Монгол улсын төрийн ба бусад байгууллагын ажилчдын гадаад оронд хурал, зөвлөгөөнд оролцсон, ажилласан томилолтын зардлын судалгаа,
5. Олон улсын байгууллага, гадаад орнуудын засгийн газар, бусад оршин суугч бусын зардлаар Монгол Улсад зохион байгуулагдсан хурал, семинар, зөвлөгөөний зардлын судалгаа,
6. Гадаадад суралцаж буй Монгол оюутны судалгаа,
7. Монгол иргэдийн гадаадад эмчлүүлсэн зардлын судалгаа,
8. Монгол улсад ирж буй гадаадын жуулчдын судалгаа,
9. Хилийн боомтын валютын урсгалын судалгаа,
10. Импортын тээвэр, даатгалын үйлчилгээний зардлын судалгаа.

Зарим судалгааны үр дүнг цахим хуудаснаас үзнэ үү.

3.2 Мэдээллийн эх сурвалжийн чанарын шалгалт

Макро эдийн засгийн хандлага, зах зээл дээрх шинэ бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээнээс хамааран төлбөрийн тэнцлийн мэдээллийн эх сурвалж байнга өөрчлөгдөж байна. Иймд Монголбанкнаас төлбөрийн тэнцлийн мэдээллийн эх сурвалжид чанарын шалгалтыг жил тутам гүйцэтгэж, мэдээллийн эх сурвалжийг өөрчилж байдаг.

IV. БОЛОВСРУУЛАЛТ

4.1 Мэдээлэл цуглуулах

Төлбөрийн тэнцлийн мэдээллийн эх сурвалжийг дараах хугацаанд цуглуулдаг. Үүний дараагаар техникийн шинжтэй алдаа, залруулгыг шалгах, мэдээллийн эх сурвалжуудыг тулгах, бусад үзүүлэлттэй нийцтэй байдлыг шалгах зэрэг ажлуудыг гүйцэтгэдэг.

Хүснэгт 2. Мэдээллийн эх сурвалж

№	Мэдээний нэр	Хугацаа
1	Банкуудын гадаад гүйлгээний мэдээ	Дараа сарын 10-ны өдрийн дотор
2	Банкуудын сарын мэдээ	Дараа сарын 10-ны өдрийн дотор
3	Төрийн байгууллагуудын мэдээ	Дараа сарын 15-ны өдрийн дотор
4	Бусад байгууллагуудын сарын мэдээ	Дараа сарын 15-ны өдрийн дотор
5	Аж ахуйн нэгжийн шууд мэдээ	Дараа улирлын эхний сарын 25-ны өдрийн дотор
6	Бусад байгууллагуудын улирлын мэдээ	Дараа улирлын эхний сарын 25-ны өдрийн дотор

4.2 Боловсруулалт, нэгтгэл

Төлбөрийн тэнцлийн боловсруулалт, нэгтгэлийг “Монгол Улсын төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлийг боловсруулах аргачлал”-ын дагуу гүйцэтгэнэ.

4.3 Гүйцэтгэлийн хяналт

Монголбанкны төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлийг хариуцсан нэгжийн боловсруулсан тайлан, мэдээнд дараах байдлаар хяналт тавьсны үндсэн дээр олон нийтэд мэдээлнэ.

№	Хяналтын үе шат	Албан тушаалтан
1	Техникийн хяналт	Нэгжийн хэлтсийн захирал
2	Бусад үзүүлэлттэй уялдаатай байдлын хяналт	Нэгжийн газрын захирал
3	Мэдээллийн эх сурвалжийн хяналт	Харьяалсан Дэд ерөнхийлөгч
4	Нийтэд мэдээлэх зөвшөөрөл өгөх	Ерөнхийлөгч

4.4 Гүйцэтгэлд тохируулга хийх бодлого

Төлбөрийн тэнцлийн сарын гүйцэтгэл нь улирлын мэдээгүйгээр буюу аж ахуйн нэгжийн мэдээ, бусад мэдээллийн эх сурвалжийг ашиглахгүй гаргадаг тул улирлын гүйцэтгэлийг гаргасны дараагаар сарын гүйцэтгэлд дараах байдлаар залруулга хийгдэнэ.

№	Урьдчилсан гүйцэтгэл	Эцсийн гүйцэтгэл	Хугацаа
1	Сарын урьдчилсан гүйцэтгэл	-	T
2	Сарын гүйцэтгэл	Улирлын гүйцэтгэл гарсны дараагаар сарын гүйцэтгэлийг шинэчилнэ.	T+3 сар
3	Сарын эцсийн гүйцэтгэл	Жилийн эцсийн гүйцэтгэл гарсны дараагаар сарын эцсийн гүйцэтгэлийг гаргана.	Дараа жилийн 4 дүгээр сард
4	Улирлын гүйцэтгэл	-	T

5	Улирлын эцсийн гүйцэтгэл	Жилийн эцсийн гүйцэтгэл гарсны дараагаар улирлын эцсийн гүйцэтгэлийг гаргана.	Дараа жилийн 4 дүгээр сард
6	Жилийн гүйцэтгэл	4-р улирлын гүйцэтгэл гармагц, жилийн гүйцэтгэлийг улирлын гүйцэтгэлүүдийн нийлбэрээр тодорхойлно.	Т
7	Жилийн эцсийн гүйцэтгэл	Гадаад худалдааны жилийн эцсийн мэдээ, аж ахуйн нэгж, байгууллагуудын жилийн эцсийн гүйцэтгэл гарсны дараагаар гаргана.	Дараа жилийн 4 дүгээр сард

Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлд залруулга хийхдээ дараах бодлогыг баримтална:

1. Дараа улирлын гүйцэтгэл гарах хүртэлх хугацаанд сарын урьдчилсан гүйцэтгэлд өөрчлөлт оруулахгүй,
2. Жилийн эцсийн гүйцэтгэл гарахаас нааш улирлын гүйцэтгэлд өөрчлөлт оруулахгүй,
3. Аль улирлын өөрчлөлт болохыг тодорхойлох боломжгүй үед өөрчлөлтийг 4 дүгээр улиралд оруулна.
4. Гадаад худалдааны гаалийн жилийн статистикт өөрчлөлт орохтой холбогдон урьдчилсан байдлаар нэгтгэн гаргасан төлбөрийн тэнцлийн урсгал дансны гүйлгээний дүн өөрчлөгддөг.
5. Урьдчилсан байдлаар гаргасан төлбөрийн тэнцэлд холбогдох өөрчлөлтийг тусгаж эцэслэн 2 дугаар улиралд багтаан гаргадаг.

V. НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ

5.1 Мэдээллийг тархаах

Монголбанк нь төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлийг дараах хуваарийн дагуу боловсруулж, цахим хуудас (www.mongolbank.mn)-аар дамжуулан нийтэд мэдээлдэг.

Хүснэгт 3. Төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлийг тархаах хуваарь

№	Төлбөрийн тэнцлийн мэдээ	Цахим хуудсанд тавигдах огноо
1	Сарын гүйцэтгэл	Дараа сарын ажлын сүүлийн өдрийн дотор
2	Улирлын гүйцэтгэл	Дараа улирлын 2 дахь сарын 15-ны өдрийн дотор
3	Улирлын тойм	Дараа улирлын 2 дахь сарын 25-ны өдрийн дотор
4	Жилийн урьдчилсан гүйцэтгэл	Дараа улирлын 2 дахь сарын 15-ны өдрийн дотор
5	Жилийн урьдчилсан гүйцэтгэлийн тойм	Дараа улирлын 2 дахь сарын 25-ны өдрийн дотор
6	Жилийн эцсийн гүйцэтгэл	Дараа жилийн 4 дүгээр сарын 15-ны өдрийн дотор
7	Жилийн эцсийн гүйцэтгэлийн тойм	Дараа жилийн 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор

Төлбөрийн тэнцлийг гүйцэтгэлийг холбогдох төрийн байгууллага, харилцагч аж ахуйн нэгж, төрийн байгууллагад цахим шуудангаар хүргүүлэхийн зэрэг ОУВС, Дэлхийн банк, АХБ зэрэг олон улсын байгууллагуудын мэдээллийн санд тогтсон хэлбэрээр мэдээг оруулдаг.

5.2 Аргачлалтай танилцах боломж

Төлбөрийн тэнцлийн аргачлалыг Монголбанкны цахим хуудаснаас татаж авах боломжтой.

5.3 Хэрэглэгчдэд үзүүлэх туслалцаа

Монгол Улсын төлбөрийн тэнцлийн гүйцэтгэл, гадаад хөрөнгө оруулалтын позиц, гадаад зээлийн тойм, гадаад худалдааны тойм зэрэг гадаад секторын үзүүлэлтүүдийн талаарх мэдээллийг Монголбанкны цахим хуудаснаас татаж авч болно.

VI. ХЭРЭГЛЭЭ

Монгол Улсын төлбөрийн тэнцлийн гүйцэтгэлийг Сангийн яам, Монголбанк, олон улсын санхүүгийн байгууллагууд нь макро бодлогыг боловсруулах, хэрэгжилтийн явц, үр дүнг үнэлэх, иргэд, аж ахуйн нэгж нь хөрөнгө, эх үүсвэрийн удирдлагын шийдвэр гаргалтанд ашиглаж байна.